Эрүүл мэнд спортын сайдын 2016 оны 2 сарын 23 өдрийн 52 дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллагад өгөх
ЗӨВЛӨМЖ
(Маягт №3)

2025 оны 04 сарын 02-ны өдөр

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ ТЭМТ-Д**

| № | Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Зөвлөмж | Хэрэгжүүлэх арга зам |
|---|---|---|---|---|
| **БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | |
| **ДЭД БҮЛЭГ 1: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ** | | | | |
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг таньж, тусламж, үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг хийсэн байх | 1.3 | "Эрүүл мэндийн тухай" хуулийн 43.1 дэх заалт, "Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5081:2013 стандартын 12.6, 12.9.1.1, 12.9.1.3 дэх заалт, ЭМС-ын 2022.07.04-ний өдрийн А/352 дугаар тушаалаар батлагдсан Үйлчлүүлэгчийг танин тодруулах журам"-ыг хэрэгжүүлэх | - Сонсголын болон хэл ярианы, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах журмыг боловсруулан батлах<br>- Харааны болон сонсголын, хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах ажилтанг мэргэжлийн байгууллагатай хамтран бэлтгэх, сургах<br>- Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж байгаа үйл явцыг ЭМТҮЧАБ-ын баг хянадаг байх<br>- Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлэх, тэргэнцэртэй болох |
| 2 | Үйлчлүүлэгчид хийгдсэн яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуг бүртгэх мэдээлэх, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон, мөрддөг байх | 3.1 | Өвчтөнд хийгдсэн яаралтай шинжилгээний, шинжилгээний аюултай хариуг бүртгэх мэдээлэх, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг журамласан, мөрддөг байх | - Яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуны өгөгдөлийг /жагсаалт/ тодорхойлж, аюултай хариуг бүртгэх, мэдээллэх, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон журам боловсруулж ЭМТ -ийн дарга батлах<br>- Журмын дагуу үйл явцын зураглал хийж мөрддөг байх<br>- Шинжилгээний аюултай хариуг тэмдэглэл хөтөлдөг бүртгэлтэй байх<br>- Шинжилгээний үр дүнг хүлээн авагч бүрэн бүртгэл хөтлөн хүлээн авч, буцаан унших, заавар өгөгч эргүүлэн уншиж дахин баталгаажуулж хэвшсэн, хянадаг байх |
| 3 | Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдлыг хангах зааврагтай, мөрддөг байх | 5.1 | Мэс ажилбар хийх заавартай, ажилбар хийх бэлэн байдлыг хангах | - Мэс ажилбар хийх заавар боловсруулан батлах<br>- Мэс ажилбар хийх иж бүрдлийн бэлэн байдлыг хангах<br>- Өдөр тумын хяналт хийж, нөхөн хангалтыг хийдэг байх |
| **ДЭД БҮЛЭГ 2. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх | 1.1 | “Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа”-ны MNS 5081:2013 стандартын 6.5 дахь заалтыг хэрэгжүүлэх | - Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн журмуудыг шинэчлэн /үйл явц, процессын зураглал тодорхой/ боловсруулж, ЭМТ-ийн дарга тушаалаар журам гаргах үндэслэлийг /холбогдох эрх зүй, ЭМС-ын батласан тушаал, заавар, СЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагааны стандарт г.м/ тодорхой бичиж баталгаажуулсан байх<br>- Хамт олонд танилцуулах<br>- Журмын хэрэгжилтэнд хяналт тогтмол тавьж, үнэлгээ өгч ажилладаг байх |
| 5 | Тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, эмнэлзүйн зааварт үндэслэн үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх шалгуурыг баталсан, мөрддөг байх | 3.2 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа“ MNS 5081:2013 стандартын 8.3.1 заалтыг мөрдөх | - Тусламж үйлчилгээний стандарт, удирдамж, зааврыг үндэслэн хэвтүүлэн эмчлэх шалгуур, өвчин эмгэгийн жагсаалт гарган, СЭМТ-ийн даргаар батлуулах<br>- Шалгуурын дагуу хэвтүүлдэг, бүртгэл хөтөлдөг байх<br>- |
| 6 | Эмнэлгийн лавлагаа шатлалын тусламжид илгээсэн үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьдаг байх | 3.4 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа“ MNS 5081:2013 стандартын 8.3.7 заалт, ЭМС-ын 2021 оны “Журам батлах тухай” А/813 тушаалыг хэрэгжүүлэх | - Холбогдох тушаалыг үндэслэн, сумын ЭМТ-өөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчийг илгээх журам боловсруулан, батлуулж мөрдөх<br>- Тусламж, үйлчилгээнд илгээсэн үйлчлүүлэгчийн бүртгэл хөтөлдөг байх<br>- Үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эргэн мэдээлэл, хяналтыг хийж хэвших<br>- Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагынүйлчлүүлэгчийн эмчилгээ, үргэлжлүүлэн хийгдэх тусламж, үйлчилгээ, зөвлөмжийг хэрэгжүүлдэг байх |
| 7 | Тусламж үйлчилгээ авахаар ирсэн тохиолдол бүрт бүртгэл хөтөлж, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлдөг байх | 3.5 | ЭМС-ын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/611 дүгээр тушаалын 11 дүгээр хавсралт Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ-13А, СТ-13Б–г хөтлөх | - Хүлээн авах яаралтай тусламжийн хэсэгт үйлчилгээ авахаар ирсэн үйлчлүүлэгч бүрийг “Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн бүртгэл” СТ-13Б –д бүртгэж, яаралтай тусламжийн хуудсаар СТ-32 А /насанд хүрэгчид/, СТ-32Б /хүүхэд/, СТ-32В /эх барих, эмэгтэйчүүд/ эрэмбэлж, үзүүлсэн тусламж үйлчилгээ, өгсөн зөвөлгөөний талаар тэмдэглэл хөтөлдөг байх<br>- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийг хүлээн авах хэсэгт “Эмчлүүлэгчийг эмнэлэг (сувилалд) хүлээн авсан бүртгэл” СТ-13А-д тус тус бүртгэдэг байх<br>- Хяналт хийдэг байх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Өвчний түүх, амбулаторийн карт /жирэмсний хяналтын, хүүхдийн өсөлтийн/-ын хөтлөлт бүрэн байх | 3.7 | "Өвчний түүх бичих стандарт" MNS 4621-98 заалт, ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаал, 11 дугаар хавсралтыг баримтлан ажиллах | - Өвчний түүх, амбулаторийн картыг стандартын дагуу хөтлөх<br>- Өвчний түүх, амбулаторийн картын бичилтэд чанарын баг, СЭМТ-ийн удирдлага хяналт тавьдаг байх<br>- Өвчний түүх бичилтэд ижил мэргэжилтний үнэлгээ хийдэг байх |
| **ДЭД БҮЛЭГ 3: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ МЭДЭЭЛЭЛЭЭР ХАНГАХ** | | | | |
| 9 | Лавлагаа мэдээллийн хөтөч/ажилтан, лавлагаа өгөх цэг ажиллуулдаг байх | 1.1 | Лавлагаа мэдээллийн цэг хөтөч ажилтанг тогтмол ажиллуулах, үйлчлүүлэгчдэд өгөх мэдээллийг ил байршуулах, үйлчлүүлэгчдийг мэдээллээр бүрэн хангах, цахим хуудсаар мэдээллийг тогтмол тавьдаг байх | - Үйлчлүүлэгчид үзүүлж буй тусламж үйлчилгээний жагсаалт, багц, хөнгөлөлт, тасаг нэгжийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг мэдээллийн самбарт цаасаар болон цахимаар ил тод байршуулах<br>- СЭМТ-ийн зохион байгуулалт, тусламж үйлчилгээний чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээ, хаягжилтыг ил харагдахуйц, ойлгомжтой болгох, дуугүй хөтөч ажиллуулах<br>- Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны материалыг өөрийн СЭМТ-ийн үйлчлүүлэгчдийн онцлог, тусламж үйлчилгээний чиглэлд нийцүүлэн лавлагаа, мэдээллийн цэг, цахим хаягт байршуулах, байнга шинэчлэх |
| 10 | Цаг товлох үйлчилгээ үзүүлдэг байх | 1.3 | ЭМС-ын 2020 оны А/478 дугаар тушаал "Эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн цаг товлох үйлчилгээг утсаар зохицуулах журам"-г хэрэгжүүлэн ажиллах | - Байгууллагын хүрээнд мөрдөх оношилгоо, давтан үзлэг болон хэвтэн эмчлүүлэх зэрэг үйлчилгээний цаг товлох, чиглүүлэх үйл ажиллагааны заавар боловсруулж, СЭМТ-ийн даргаар батлуулан мөрдөх<br>- Цаг товлох үйлчилгээ хариуцсан ажилтныг томилон ажиллуулах |
| 11 | Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг тодорхойлж, баталгаажуулсан байх | 2.1 | "Эрүүл мэндийн тухай хууль"- 8 дугаар зүйлийн 43 дахь хэсэг, "Эрүүл мэндийн даатгалын тухай хууль"- 7 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тушаалын 2 дугаар хавсралт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 07 сарын 07-ны өдрийн С/31 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023"стандартын 5 дахь хэсэг "Үйлчлүүлэгчийн харилцааны ерөнхий шаардлага" -р батласан эрх үүргийг ил тод байршуулах | - Холбогдох эрх зүйн бичиг баримтанд заасан үйлчлүүлэгчийн эрх, үүргүүдийг эмнэлэгт үйлчлүүлэгчид харагдахаар ил байршуулах<br>- Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн эрх үүрэг, ёс зүйн хэм хэмжээний талаар үйлчлүүлэгч болон ажжиллагсдад сургалт явуулах удирдамж боловсруулж, СЭМТ-ийн даргаар батлуулан жил бүр хэрэгжүүлэн ажиллах<br>- Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, харилцааны ур чадварт эмнэлгийн мэргэжилтэнг сургах |
| 12 | Үйлчлүүлэгч тусламж үйлчилгээний явцад биеийн хэл, ярианы, соёлын | 2.2 | МУ-ын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн | - Биеийн, хэл ярианы, соёлын болон бусад саад бэрхшээлтэй үйлчлүүлэгч ирэх үед үзүүлэх журмыг боловсруулан батлуулсан байх, эмнэлгийн ажилчдад журмыг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | болон бусад саад бэрхшээл, чирэгдэлгүй үйлчилгээ авах нөхцөлийг хангасан байх | | 20.2 заалт, "Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5081:2013 стандартын 12.6 заалтын мөрдөж ажиллах | танилцуулсан байх<br>- Биеийн, хэл ярианы, соёлын болон бусад саад бэрхшээлтэй үйлчлүүлэгч ирэх үеийн үйл явцын зураглал гаргаж тусламж үйлчилгээг эхлэн үзүүлж буй хэсгүүдэд байршуулан тогтмол хэрэглэдэг байх, үйл явцын хяналтын цэгийг тодорхойлон хянаж, үр дүнг хэлэлцдэг байх<br>- Эмнэлгийн орц, гарц, гадаа, дотор орчинд тэргэнцэртэй хүн саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх |
| 13 | Байгууллага нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээтэй холбоотой мэдээллийг үнэн зөв өгдөг байх | 3.2 | Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 49/А/118 хамтарсан тушаал, ЭМС-ын 2022 оны А/216, А/407 дугаар тушаал, MNS 7014:2023 стандартыг мөрдөн ажиллах | - Байгууллага нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээтэй /тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөртэй эмчилгээний мэдээлэл, ЭМД багц мэдээлэл гэх мэт/ холбоотой мэдээллийг үнэн зөв ил тод мэдээлэх |
| 14 | Байгууллагын удирдлагууд үйлчлүүлэгч болон ажилтантай уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг байх | 4.1 | ЭМС-ын 2022 оны 01 сарын 25-ны өдрийн "Журам батлах тухай" А/50 дугаар тушаалыг мөрдөж хэрэгжүүлэх | - Байгууллагын дарга үйлчлүүлэгч, ажилтантай уулзах баталсан хуваарь батлах<br>- Иргэдээс биеэр, бичгээр, утсаар ирсэн анал хүсэлтийг хүлэээн авч бүртгэдэг байх<br>- Гаргасан санал, хүсэлтийг шийдвэрвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх<br>- ЭМС-ын ЭМС-ын 2022 оны 01 сарын 25-ны өдрийн Журам батлах тухай А/50 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээний загвар хүснэгтийг бөглөж Аймгийн ЭМГ-т улирал, хагас, бүтэн жилээр хүргүүлдэг байх |
| 15 | Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байх | 4.3 | ЭМС-ын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/346 тоот тушаалын "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" 1 дүгээр хавсралтын 5.8.3 дах заалтын дагуу үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлтийг сар бүр авдаг байх, удирдлагын багт танилцуулан, шийдвэрлэж, ил тод мэдээлдэг, авсан арга хэмжээний дагуу ажил зохиодог байх | - Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг цахим, утсаар, амаар болон бичгээр авч арга хэмжээг хэрэгжүүлэх журам боловсруулан батлах<br>- Хариуцсан ажилтанг томилох, журамд үүргийг нь тодорхой тусгах<br>- Ирсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын бүртгэлийг хөтлөдөг байх<br>- Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж, сэтгэл ханамжийн үнэлгээг хийж судалгааг улирал бүр авдаг болох<br>- Удирдлагын багт танилцуулан дүгнэлт гаргадаг байх, дүгнэлтийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжүүлэх<br>- Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд хариу өгдөг байх |
| 16 | Авилгаас ангид байх, албан бус төлбөр, бэлэг авах, өгөх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх | 4.5 | ЭМС-ын 2019 оны 09-р сарын 04-ны А/406 тоот тушаалын 1-р хавсралт "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийн 4.15 заалтыг | - Байгууллагын дотоод журамд албан бус төлбөр, бэлэг авах, өгөхийг хориглосон заалт оруулан шинэчлэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих<br>- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ, дүгнэлт гаргадаг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мөрдөх | байх |
| **ДЭД БҮЛЭГ 4. ҮЗЛЭГ ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭ** | | | | |
| **А. АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | |
| 17 | Амбулаторийн үзлэгийн хэсэг, өрөөнүүдийг зохион байгуулж, үзлэг оношилгоог бүрэн хийдэг байх | 1.1 | Амбулаторийн үзлэгийн өрөөг хэвтэн эмчлүүлэх 2 давхараас тусад нь зохион байгуулах | - Амбулаторийн үзлэгийн өрөөнүүдийг 1 дүгээр давхарт байхаар зохион байгуулах /2 эмчийн болон, эмэгтэйчүүдийн үзлэгийн өрөө/<br>- Лабораторит эмчийн үзлэг хийхгүй байх |
| 18 | Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалттай байх | 1.3 | Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлийн стандарт MNS 4621:2008 –ын дагуу амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг баталсан байх | - Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг шинэчлэн /үйлдэл, ажилбар бүрт тохирох стандартын хамт жагсаах/ ЭМТ-ийн даргаар батлуулсан байх<br>- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, баталгаажуулан, гарын авлагаар хангасан байх<br>- Ажилбар үйлдлийг стандартын дагуу хийдэг, хянадаг, үр дүнг тооцож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг байх<br>- Эмч мэргэжилтнүүд үйлдийг хийх ур чадвар эзэмшсэн байх |
| **Б. ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | |
| 19 | Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийдэг | 2.2 | Жил бүр хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний байдалд судалгаа хийж, судалгааны дүгнэлтэд үндэслэн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байх | - Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний байдалд судалгаа хийж, тэргүүлэх өвчлөлүүдийг тогтоох<br>- Судалгааны дүгнэлтэнд үндэслэн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг тогтоодог байх<br>- Судалгааны тайлантай, авсан арга хэмжээний үр дүнг тооцсон, үнэлэлт дүгнэлттэй байх |
| 20 | Яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн хангалтанд үнэлгээ хийх | 2.3 | Хүлээн авах, яаралтай тусламжийн хэсэгт яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлыг тогтмол хагаж байх | - Хэвтэн эмчлүүлэх хэсэгт яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллах<br>- Тариа, ажилбар хийдэг өрөө бүрт яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг батласан байх<br>- Өрөө бүрийн жагсаалтын дагуу хяналтын хуудас боловсруулж, үнэлгээ хийж бэлэн байдлыг хянадаг байх,<br>- ЯТҮ-г багаар үзүүлэх ур чадварыг сайжруулах<br>- Хөрвөх чадварыг эзэмшүүлэх |
| **ДЭД БҮЛЭГ 5. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ** | | | | |
| 21 | Халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын багийг зохион байгуулсан, төлөвлөгөөтэй байх | 1.1 | “Дүрэм жагсаалт батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/536 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар чиг үүргийг нь баталсан “Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааны дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллах, | - ХСХ-ын төлөвлөгөөнд халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлуудыг шат дараатай шийдвэрлүүлэхээр тусгах, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дэлгэрэнгүй гарган, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт өгдөг байх<br>- ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эмнэлгийн үйл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ХСХ-ын төлөвлөгөг өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулах | ажиллагааны урсгал зохицуулалт, халдварын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдал, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд тавих хяналтыг сайжруулах талаар төлөвлөгөөндөө тусгах, хэрэгжилтийг хангуулан, алдаа дутагдлыг арилгуулж, ахиц, дэвшил гарсан байх<br>- Ажил хавсран гүйцэтгэж байгаа мэргэжилтний үндсэн ажлаас гадна хяналтын үйл ажиллагаанд зарцуулах цагийн менежментийг зохицуулах, халдвар хяналтын ажилтанг бэлтгэж мэргэшүүлэх, ур чадварыг сайжруулах сургалтанд хамруулах |
| 22 | Халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийдэг байх | 1.2 | “Заавар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалаар батлагдсан заавруудыг хэрэгжүүлэх, Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаанд тавих хяналт, үнэлгээг сайжруулах | - Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хийх хяналт, үнэлгээг эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, тусгаарлан сэргийлэлт, халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдал, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаа, эмнэлгийн орчны цэвэрлэгээ, үйлчилгээ, хог хаягдлын менежментэд тус тус хийж, үнэлгээний дүнг ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулахад ашиглах<br>- Гадаргуун халдваргүйтгэлийг хэвшүүлж, тарилгын аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтаны халдварт өртөх эрсдэлт хүчин зүйл, ЭМБ-ын аюултай хог хаягдлын ангилан ялгалт, эмнэлгийн орчны эрүүл ахуйн шаардлага, агаар солилцооны дэглэмийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлэн, дотоодын хяналт, үнэлгээг тодорхой давтамжтайгаар хийж судалгаа, дүгнэлттэй ажиллах |
| 23 | Эрүүл мэндийн ажилтанд ХСХ-ын мэдлэг олгох сургалт хийдэг байх | 1.4 | Эрүүл мэндийн ажилтанд халдвараас сэргийлэх мэдлэгийг олгох сургалтыг үр дүнтэй явуулж, ажилтан өөрийгөө хамгаалах дадалтай болж, үйл ажиллагаандаа хэвшүүлэх | - Эрүүл мэндийн ажилтанд халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мэдлэг олгох сургалтыг мэргэшсэн, дадлага туршлагатай хүнээр ажлын байран дээр хийлгэх<br>- Сургалтын хөтөлбөрт хүн бүрийн мэдэж байх, хэрэгжүүлэх заавар, халдвараас сэргийлэх стандарт (байнгын) сэргийлэлтийн арга хэмжээ тусгагдсан байх<br>- Бусад эрүүл мэндийн байгууллагын ХСХ-ын үйл ажиллагаа, хамт олон, эрүүл мэндийн ажилтаны сайн туршлага, шинэ санааг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх<br>- Сургалтаар олж авсан мэдлэгийг дадал болгон хэвшүүлэх, хандлагыг өөрчлөх, өөрийгөө хамгаалах чадварыг эзэмшсэн эсэхэд үнэлгээ дүгнэлт хийж, чанар сайжирсан байх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 24 | Давтан хэрэглэж байгаа багаж, хэрэгслийг ариутгах ариутгалын хэсэгтэй байх | 4.1 | "Заавар батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар"-ыг баримтлан, 2 дугаар хэсгийн "Ариутгалын тасаг, хэсэгт тавигдах шаардлага"-ыг хэрэгжүүлж, аюулгүй, найдвартай ариутгалын тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах | - Ариутгалын хэсгийг ариун цэврийн өрөөнөөс гаргаж, нэг чиглэлийн урсгалтай, цэвэр, бохир хэсгээр тусгаарласан, агааржуулалт, гэрэлтүүлэг сайтай, ариун хэсгээс бохир хэсэг рүү чиглэсэн агаарын урсгалтай байхаар зохицуулах /Зориулалтын автоклавтай болтол ариутгалын үйл ажиллагааг аймгийн нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасагтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх/<br>- Зориулалтын ариутгалын тоног төхөөрөмжийг суурилуулан, үйл ажиллагаа явуулах бэлтгэлийг хангаж, техникийн хяналтыг хийлгэх, автоклавын манометрийг баталгаажуулж, шалгалт тохируулга хийлгэсэн гэрчилгээтэй байх<br>- Даралтат савыг ажиллуулах үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах, ажлын байран дээр нөөц ариутгагчийг дагалдуулан сургаж, аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан байх<br>- Автоклавын уурын нэвчилт, агаарын шилжилт хөдөлгөөнийг хянах" bowie dick" тест болон биологийн тестийн хяналтыг нэвтрүүлж, спортой нянгийн устгалаар "ариун" байдлыг шалгах |
| 25 | Мэс заслын дараахшархны халдвар илрүүлэх тандалт хийж, бүртгэж мэдээлдэг байх | 5.1 | "Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар /ЭТҮХХ/-ыг тандах заавар батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/539 тоот тушаалаар батлагдсан зааврuудыг хэрэгжүүлэх | - ЭМС-ын 2019 оны А/539 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтын нийтлэг заавар"-ыг хэрэгжүүлж, мэс заслын тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид шархны халдварыг тандах, төрсний дараа эх, нярайд халдвар илрүүлэх тандалтыг тус тус хяналтын хуудсаар хийж, эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэн халдвараас сэргийлэх арга хэмжээ авах, бүртгэл судалгааг үндэслэн Эрүүл мэндийн газарт мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх<br>- Уян зүү, шээлгүүр, амьсгалын гуурс тавих зэрэг эрсдэлтэй ажилбаруудыг гүйцэтгэх арга барилд гардан болон дагалдуулах сургалтыг зохион байгуулан дадлагажуулж, ажилбар хийх явцад халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлтөд үнэлгээ хийх, шалгуур хуудас ашиглан тандалт хийж, бүртгэл, судалгаатай ажиллах |
| 26 | Халдварт өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зохион байгуулалт хийдэг байх | 6.2 | Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5081:2013 стандартын 8.3.8 дах заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 тоот тушаалын 9 дүгээр хавсралтаар баталсан "Тусгаарлан | - Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шаардлагатай үед халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлан эмчлэх<br>- Халдварт өвчний дэгдэлтийн үед үйл ажиллагааны урсгалыг зохицуулахаар үзүүлэх сургууль зохион байгуулж, дайчлах схемийг боловсруулах, зураглал гаргах, дадлага, туршилтыг хийж, бэлэн байдлыг хангаж ажиллах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сэргийлэлтийн арга хэмжээний заавар” -ыг мөрдөж ажиллах | - Эрүүл мэндийн байгууллагын орчин, ажиллагсад, бусад үйлчлүүлэгчид халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээг зохицуулах, халдвар дамжих замд суурилсан нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх |
| 27 | Аюултай хог хаягдлын устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх | 9.4 | “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” ЭМС-ын 2017 оны 505 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “ЭМБ-ын аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах заавар”-ыг мөрдөж ажиллах | - Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын устгалд зориулагдсан өндөр даралтын уурын автоклавыг зориулалтын дагуу ашиглах, бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, ажилтныг мэргэшүүлэх сургалтанд хамруулах<br>- Аюултай хог хаягдалтай харьцах үеийн халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлаж ажиллах<br>- Эмнэлгээс гарч буй хог хаягдлын сар бүрийн бүртгэл судалгааг үндэслэн, хогны хэмжээг бууруулах, менежментийг сайжруулах арга хэмжээ авах |
| **БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | |
| **ДЭД БҮЛЭГ 1: ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ** | | | | |
| 28 | Бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг хийсэн байх | 2.1 | ЭМБ-тай гэрээ байгуулж хамтран ажилладаг байх | - Эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээтэй хамтран ажиллах өөрийн төвийн ерөнхий журам боловсруулан батлах /гэрээг хийх чиглэлүүдийг, гэрээ хийх хугацаа, дүгнэх шалгуур зэргийг тодорхой тусгах /<br>- **Ариутгалын зориулалтын аппарат, тоног төхөөрөмжтэй болтол АНЭ-тэй ариутгалын тусламжаар гэрээ хийж ажиллах, ариутгалын ажилтанг сургах**<br>- Жил бүр гэрээний биелэлт, үр дүнг тооцдог байх |
| 29 | Тасаг, нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааны зохицуулалтыг хийсэн байх | 2.2 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.5 дахь заалт,<br>ЭМС-ын 2021 оны “Журам батлах тухай” А/813, А/814; ЭМС-ын 2023 оны А/220 дугаар тушаалыг хэрэгжүүлэх журмуудыг боловсруулахдаа<br>Монгол улсын MNS:5140:1:2021, MNS 5140:2:2021,<br>MNS 5140:3:2021-баримт бичгийн стандартыг мөрдөх | - СЭМТ-ийн амбулатори, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, лавлагаа шатлалын эмнэлэгтэй үйлчлүүлэгч шилжүүлэх, тээвэрлэх, бүртгэх, хянах, эргэн мэдээлэх тусламж үйлчилгээг зохицуулсан журам боловсруулж, даргын тушаалаар батлах<br>- Эмнэлэгт хэрэглэж байгаа журам, тушаал зэрэг албан бичиг баримтыг дурдсан баримт бичгийн стандартын дагуу боловсруулж хийж хэвших, хүний нөөцийн ажилтанг сургах<br>- Журмыг эмнэлгийн нийт албан хаагчдад танилцуулж баталгаажуулах<br>- Журмын хэрэгжилтэнд хяналт тавьдаг, үнэлдэг байх |
| 30 | Удирдлагын багийн үйл ажиллагаа хэвшиж, үр дүнтэй ажилладаг байх | 4.1 | Удирдлагын багийн үйл ажиллагааг хэвшүүлэх | - Удирдлагын багийн үйл ажиллагааг хэвшүүлэх, багуудыг ажлын үр дүнг хэлэлцдэг, сайжруулах арга хэмжээ авдаг байх<br>- Хэлэлцсэн, шийдвэрлэсэн асуудлын тухай жил бүр тайлан гаргадаг, хэлэлцэг байх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 31 | Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр/ төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнтэй ажилладаг байх | 6.5 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын, 12.5.2; 12.9.2.6; дахь заалтыг хэрэгжүүлэх | - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг жил бүр боловсруулан, батлаж, хэрэгжүүлэн ажиллах<br>- Ажлын байрны орчны /актлагдсан барилгад/ үнэлгээг хийж гарч болох эрсдэлийг бууруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх, үр дүнг тооцдог байх<br>- ХАБ-ын ажилтанг томилох, үүрэгжүүлэх<br>- Ажилтнуудыг хувийн хамгаалах хэрэгслэлээр хүртээмжтэй хангадаг байх |
| **ДЭД БҮЛЭГ 2: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН УДИРДЛАГА** | | | | |
| 32 | “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” /Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө/-тэй, хэрэгжүүлж, хянадаг байх | 1.1 | ЭМС-ын 2024 оны А/112 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах заавар”-ыг хэрэгжүүлэх | - Холбогдох тушаалд заасны дагуу чанар, аюулгүй байдлыг сайжруулах 10 зорилттой төлөвлөгөөг боловсруулан төвийн дарга батлан, аймгийн ЭМГ-ын холбогдох ажилтнаар баталгаажуулна<br>- Хагас жил, бүтэн жилд тайлан гаргах<br>- СЭМТ-ийн даргаар томилсон баг нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөнд жилд 2 удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийдэг байх<br>- Төв нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөгөө Магадлан итгэмжлэлийн цахим системд жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор байршуулж баталгаажуулдаг байх<br>- Төв нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Магадлан итгэмжлэлийн цахим системд байршуулдаг байх |
| 33 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал /ЭМТҮЧАБ/-ын багийн үйл ажиллагаа тогтмолжсон, асуудалд чиглэсэн тодорхой, үр дүнтэй ажилладаг байх | 1.2 | МУ-ын Шадар сайд, ЭМС-ын хамтарсан 2019 оны 116/А565, 2019 оны А/566 /1,3 дугаар хавсралтаас бусад/, 2024 оны А/112 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэх | - ЭМТҮЧАБ-ын багийн тушаалыг шинэчлэн гаргах, ажиллах журмыг холбогдох тушаалуудыг үндэслэн шинэчлэн боловрсуулж батлах<br>- Чанар,аюулгүй байдлын багийн гишүүдийн албан тушаалын тодорхойлолт /АТТ/-д холбогдох тушаал, шийдвэрт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгаж баталсан байх<br>- АТТ-д заасан чиг үүргийн дагуу ажиллуулдаг байх<br>- Баг нь төлөвлөгөөтэй, хэрэгжүүлдэг, хянадаг тогтолцоотой, байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд жил бүр дүн шинжилгээ хийсэн, гарсан ахиц, үр дүн үр дүнг тооцдог байх |
| 34 | Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд дотоод хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх | 2.1 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.4.3; 6.4.4 дахь заалтыг хэрэгжүүлэх,<br>“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний | - Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр дотоод хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөө, графиктай байх<br>- Хяналт, үнэлгээнд хяналтын хуудсууд /ганц сувилахуй биш, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж заавар ашиглан эмнэлзүйн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | чанар сайжруулах зарим арга хэмжээний тухай" ЭМС-ын 2019 оны А/566 тушаалын 2, 4, 6 дугаар хавсралт, хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр дотоод хяналт тогтмол хийдэг байх | хяналт хийх хуудас боловсруулах/ ашигладаг байх<br>- Хяналт, үнэлгээ хийсэн тайлан, дүгнэлт, үр дүнтэй байх<br>- Дотоод, хяналт үнэлгээний дүгнэлтэд үндэслэн ажил сайжруулах ажлын зөвлөмж, өгдөг, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байх<br>- Дотоод хяналт, үнэлгээгээр илэрсэн асуудлыг удирдлагын зөвлөлд танилцуулдаг шийдвэрлэдэг байх<br>- Ажил сажруулах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх, үйл ажиллагаа сайжирсан, үр дүн гарсан тайлантай байх |
| 35 | Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх. | 2.2 | Тусламж үйлчилгээний нэгж бүрт үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ тогтмол хийдэг байх | - СЭМТ-ийн үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний төрөл бүрээр чанар, аюулгүй байдлын өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан даргын тушаалаар батлах<br>- Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр баталсан шалгуур үзүүлэлтийг тогтмол /сар, улирал, хагас, бүтэн жилээр/ хэмжиж, дүн шинжилгээ хийдэг, өмнөх жилүүдийн үзүүлэлттэй болон ижил төстэй үйл ажиллагаатай ЭМБ-ын үзүүлэлттэй харьцуулан дүгнэлт гаргадаг, тайлантай байх<br>- Үр дүнг нийт ажилтнуудад танилцуулдаг байх, шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээ авдаг байх<br>- Үндэсний болон олон улсын түвшинд мөрддөг үзүүлэлтүүдтэй харьцуулж, сайжруулах арга хэмжээ авч ажилладаг байх |
| 36 | Тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах журамтай, зохион байгуулалтыг бүх тасаг, нэгжид хийсэн байх | 4.1 | СЭМТ-д үзүүлэх тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох | - Өөрийн эмнэлэгт үзүүлэх тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах журам боловсруулж батлах, хэрэгжүүлэх<br>- Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах тодорхой чиглэсэн ажлууд /сургалт, тусламж үйлчилгээн дэх журмын мөрдөлт гм/ төлөвлөн хийдэг<br>- Авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг дүгнэдэг байх |
| 37 | Тусламж, үйлчилгээг үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх | 4.2 | ЭМС-ын 2024 оны А/112 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтын дагуу тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх, ЭМС-ын 2022 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай" А/136 дугаар | - Холбогдох журам, зааврыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тохиолдол бүртгэх, хариу арга хэмжээ авах журмыг боловсруулан батлах<br>- http://eburtgel.moh.gov.mn/ нэгдсэн мэдээллийн санд нэгдэх, эмнэлгийн хаягыг үүсгэж, зааврын дагуу тохиолдол, эрсдлийг бүртгэж мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх<br>- Бүртгэгдсэн тохиолдол бүрт дүн шинжилгээ хийн, хэлэлцүүлэг хийдэг байх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | тушаалын 2 дугаар хавсралтын 1.2.2 заалтыг хэрэгжүүлэх | - Тохиолдлын мөрөөр арга хэмжээ авч, хэрэгжүүлдэг, зэмлэн буруушаахгүй, тохиолдолыг илрүүлж засах арга хэмжээ авч амжилттай ажилласан тасаг, нэгж, ажилтанг урамшуулдаг байх<br>- Жил бүрийн тайлантай байх |
| 38 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа зохион байгуулдаг байх | 4.3 | Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлдэг байх | - Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэх журам боловсруулж батлах<br>- Журмыг хэрэгжүүлдэг байх<br>- Журмын хэрэгжилтэнд хяналт тавьдаг байх |
| 39 | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой сургалтыг эмнэлгийн нийт ажилтнуудад /эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтнүүдэд/ тогтмол зохион байгуулдаг байх | 4.4 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.6.8; 12.9.1 дэхь заалтыг хангахад шаардлагатай сургалтыг зохион байгуулдаг байх | - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой сургалтын удирдамж, хөтөлбөр гаргаж, эмнэлгийн ажилтнуудад тогтмол сургалт зохин байгуулдаг байх<br>- Өөрийн эмнэлэгт батласан үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын журмыг таниулах сургалтыг эмнэлгийн ажилтнуудад хийдэг байх<br>- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдрийг тухайн жилийн уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг, үр дүнгээ тооцдог байх<br>- Сургалт зохион байгуулсан, мэдлэгийг дээшлүүлсэн тайлантай байх |
| 40 | Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын ажилтнуудыг сургадаг байх | 5.2 | Эрсдэлийн чиглэлээр сургалтыг хийдэг, сургалтанд хамрагдаг, эрсдлийг үнэлэх, хариу арга хэмжээ авах чадвараа сайжруулдаг байх | - Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд эрсдэлийн чиглэлээр хийх онолын болон дадлагын сургалтыг оруулж байх<br>- Сургалтын удирдамж, хөтөлбөр, материал, хийсэн тайлантай байх<br>- Эрсдэлийн чиглэлээр хийгдэж буй гадаад /ЭМГ, БОЭТ болон цахим сургалт/ сургалтуудад хамрагддаг байх |
| 41 | Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажилладаг байх | 6.1 | Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу арга хэмжээ авдаг байх | - Аймгийн ЭМГ, даатгалын байгууллага болон бусад хөндлөнгийн байгууллагын хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр алга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг, үр дүнг эргэн мэдээлдэг байх<br>- **Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлдэг байх** |
| **ДЭД БҮЛЭГ 3: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ** | | | | |
| 42 | Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний хэрэгцээнд үндэслэн хүний нөөцийн төлөвлөлтөө хийж, хангасан байх | 1.1 | Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх | - Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх<br>- **Ариутгагч, НЭМ, дархлаажуулалтын сувилахуйгаар хангагдах, хүний нөөцийг мэргэшүүлэх** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 43 | Хүний нөөцийн хөгжлийн (төгсөлтийн дараах сургалт, эрдмийн болон мэргэжлийн зэрэг, нийгмийн хамгаалал гэх мэт) хөтөлбөр/төлөвлөгөө батлан, хэрэгжүүлдэг байх. | 1.2 | ЭМС-ын 2019 оны А/513 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу шаардлага хангасан эмнэлгийн мэргэжилтэнг мэргэжлийн зэрэг хамгаалахад нь дэмжлэг үзүүлдэг байх | - Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөнд эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн зэрэг хамгаалуулах төлөвлөлтийг хийж, дэмжлэг үзүүлдэг байх<br>- Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэнүүдтэй болох |
| 44 | Ажилтан бүрийн албан тушаалын тодорхойлолтыг тусламж, үйлчилгээний өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, баталгаажуулсан байх | 1.5 | “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.6.4 дэх заалтыг хэрэгжүүлэх<br>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 тоот тогтоолын дагуу албан тушаалын тодорхойлолтыг ажилтан нэг бүрээр гаргах | - Ажилтан бүрийн ажлын байрны чиг үүргийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлах<br>- АТТ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх ажил үүргийг тусгасан, ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг бүрдүүлэх, сайжруулах талаар тусгасан байх |
| 45 | Шинэ ажилтанг чиглүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулдаг тогтолцоо бүрдсэн байх | 2.2 | Шинэ ажилтанд чиглүүлэх сургалт хийдэг байх | - СЭМТ-д шинээр орсон ажилтанд баримжаа олгох, чиглүүлэх сургалт хийдэг хөтөлбөр батлах<br>- Батлагдсан хөтөлбөрийн дагуу шинэ ажилтанд сургалт хийдэг, баримтжуулдаг байх |
| 46 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх. | 3.3 | ЭМС-ын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” батлах тухай А/406 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, ЭМС-ын 2022 оны “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм” батлах тухай А/319 дүгээр тушаалын хавсралтуудыг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс сэргийлдэг байх | - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг байх<br>- Эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага, ёс зүйн чиглэлээр сургалт хийдэг байх<br>- Албан бус төлбөр, авилгал өгч авахаас сэргийлдэг сургалт хийдэг байх<br>- Сургалтанд ЭМБ-ын бүх ажилтнуудыг хамруулдаг байх |
| 47 | Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж, ур чадварыг дээшлүүлдэг байх. | 3.5 | ЭМС-ын 2019 оны А/513 дугаар тушаалын “Мэргэжлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам” нэгдүгээр хавсралтын заалтанд хамрагдах ЭМА-уудыг мэргэжлийн зэрэг хамгаалуулах | - Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт холбогдох тушаалын шалгуурыг хангасан эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн зэрэг хамгаалахад байгууллагаас дэмжлэг үзүүлэх, төлөвлөх<br>- Жил бүр мэргэжлийн зэрэг хамгаалсан ЭМА-ны тоог нэмэгдүүлсэн байх |
| 48 | Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан гардан үйлдлийг стандарт, удирдамж, зааврын дагуу хийх ур чадвар эзэмшсэн байх | 3.6 | СЭМТ-д хийгдэх гардан үйлдлийн жагсаалтыг гаргаж, мөрддөг байх | - Өөрийн төвд хийгддэг гардан үйлдлийн жагсаалтыг боловсруулж, батласан байх<br>- Гардан үйлдлийг холбогдох стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг байх<br>- Гардан үйлдэл бүрт холбогдох стандарт, удирдамж, зааврын дагуу хяналтын хуудас боловсруулж эмнэлгийн даргаар батлуулан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | үнэлгээ хийж, үр үнг тооцдог байх |
| 49 | Ажилтнуудын ажилд гүйцэтгэлийн үнэлгээ хийдэг, хэвшсэн байх | 4.1 | Ажилтнуудын ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгдөг, урамшуулдаг байх | - Ажилтнуудын ажилд гүйцэтгэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт, журмыг боловсруулан ЭМТ-ийн дарга батласан байх<br>- Журмын дагуу шалгуур үзүүлэлтээр сар, улирал, хагас, бүтэн жилээр үнэлгээ хийж удирдлагын багт танилцуулан хэлэлцүүлдэг, хурлын протокол хөтлөж, шийдвэрийг гаргадаг байх<br>- Журмын дагуу урамшуулал олгодог байх |
| **ДЭД БҮЛЭГ 4: МЭДЭЭЛЭЛИЙН УДИРДЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ** | | | | |
| 50 | Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд мэдээллийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг тусгасан, хэрэгжүүлдэг байх | 1.1 | "Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5081:2013 стандартын 6.3.3, 6.9.2 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийн удирлагыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг байх | - СЭТМ нь хөгжлийн төлөвлөгөөндөө иргэд болон холбогдох бусад байгууллагуудад мэдээлэл өгөх, авах чиглэлээр мэдээллийн удирдлагыг сайжруулах ажлыг төлөвлөдөг байх<br>- Мэдээллийн удирдлагын баг байгуулах, журам батлаж, жил бүр төлөвлөгөө гарган ажиллах<br>- Жилийн ажлын тайланг гаргаж, үр дүнг тооцож байх |
| 51 | Байгууллага нь тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүд, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, санхүү зэрэг чиглэлээр 5 жилээс доошгүй хугацаагаар үүссэн мэдээний сантай байх | 1.3 | ЭМС-ын 2019 оны А566 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллах | - Сүүлийн 5 жилээр байгууллагын үндсэн үзүүлэлт болон хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, санхүүгийн мэдээллийн санг үүсгэж баримтжуулах<br>- Жил бүрийн эрүүл мэндийн үзүүлэлт дээр үндэслэн үндсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргах<br>- Багаж тоног төхөөрөмжийн судалгаанд тулгуурлан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах |
| 52 | Байгууллага нь гадаад сүлжээтэй (цахим хуудас, Facebook page гэх мэт), байнга баяжилт хийгддэг, ашигладаг байх | 3.1 | Байгууллагын цахим хуудас, нүүр номын хуудаст баяжилт хийж хөтлөх ажилтныг томилж, албан тушаалын тодорхойлолтонд ажил үүргийн чиглэлийг заасан байх | - СЭМТ-ийн нүүр **номын хуудсыг /page/** нээж, иргэд мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бүрдүүлэх<br>- Цахим хуудсанд баяжилт хийдэг ажилтанг томилгоожуулж, АТТ-д энэ чиг үүргийг заасан байх<br>- Цахим хуудсанд эмнэлгийн үйл ажиллагаа, цагийн хуваарь, **яаралтай тусламжийн дуудлага авах утасны дугаар** болон иргэдэд өгөх зөвлөгөө мэдээлэлийг тогтмол тавих |
| 53 | Мэдээ мэдээллийн нууцлалыг хадгалах нөхцөлийг бүрдүүлэх | 3.3 | "Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5081:2013 стандартын 6.9.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах | - Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах журмыг гаргах<br>- Байгууллагын цахим мэдээллийн нууцыг хадгалах талаар зохицуулсан журмыг гаргах<br>- Журмыг хэрэгжүүлж, баримт бичгийн нууцлалыг хадгалах нөхцөлийг бүрдүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
